


**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ
ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ,
ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН
ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.



МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ, ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА (2022 ОНЫ ЭХНИЙ 10 САРЫН ГҮЙЦЭТГЭЛ)

ГАДААД ХУДАЛДАА (2022 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр)



Нэг. Гадаад худалдааны үзүүлэлт

Гадаад худалдааны нийт бараа эргэлт: 2022 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 17,154.3 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 30.3 хувь буюу 3,985.7 сая ам.доллороор өсөж, гадаад худалдааны тэнцэл 2,863.2 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	10 дугаар сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт 2022/2021	
	2019	2020	2021	2022	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	11,593.2	10,423.1	13,168.7	17,154.3	3,985.7	30.3
-Экспорт	6,528.7	5,986.1	7,523.5	10,008.8	2,485.2	33.0
-Импорт	5,064.6	4,437.0	5,645.2	7,145.6	1,500.4	26.6
Тэнцэл	1,464.1	1,549.1	1,878.4	2,863.2	984.8	52.4

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: 2022 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцэл 2,863.2 сая ам.долларын ашигтай гарсан байна. Гадаад худалдааны тэнцэл өмнөх оны мөн үеэс 984.8 сая ам.доллар буюу 52.4 хувиар өссөн байна.

Экспорт: 2022 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 10,008.8 сая ам.долларт хүрч, эдийн засаг хэвийн байсан 2019 оны мөн үетэй харьцуулахад 3,480.1 сая ам.доллар буюу 53.3 хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,485.2 сая ам.доллар буюу 33.0 хувиар өссөн

байна.

Импорт: 2022 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр импорт 7,145.6 сая ам.долларт хүрч, 2019 оны мөн үетэй харьцуулахад 2,081.0 сая ам.доллар буюу 29.6 хувиар, өмнөх оны мөн үеэс 1,500.4 сая ам.доллар буюу 26.6 хувиар тус тус өссөн байна.

Хоёр. Гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн

Нийт экспортын 85.1 хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт, 14.9 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна. Эрдсийн бүтээгдэхүүний экспорт 8,519.2 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс

2,210.3 сая ам.доллар буюу 35.0 хувиар өссөн бол эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт 1,489.5 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 275.0 сая ам.доллар буюу 22.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 2. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	10 дугаар сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2019	2020	2021	2022	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	5,501.6	4,228.0	6,309.0	8,519.2	2,210.3	35.0	85.1
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	1,027.1	1,758.1	1,214.6	1,489.5	275.0	22.6	14.9
Нийт экспорт	6,528.7	5,986.1	7,523.5	10,008.8	2,485.2	33.0	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ЭКСПОРТЫН ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ТОО ХЭМЖЭЭ БОЛОН ҮНИЙН ДҮН

Нийт экспортын 51.1 хувийг нүүрс, 23.4 хувийг зэсийн баяжмал, 8.2 хувийг боловсруулаагүй алт, 3.4 хувийг төмрийн

хүдэр, 2.5 хувийг цайрын баяжмал тус тус эзэлсэн байна.

Хүснэгт 3. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	10 дугаар сар (өссөн дүнгээр)				Өмнөх оны мөн үеэс	
		2019	2020	2021	2022	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян.тн	1,174.2	1,139.5	1,158.8	1,200.5	41.7	3.6
Нүүрс	сая.тн	32.3	23.9	13.5	23.1	9.6	71.7
Төмрийн хүдэр, баяжмал	сая.тн	6.7	6.9	6.6	3.9	-2.7	-40.9
Цайрын хүдэр, баяжмал	мян.тн	109.2	115.6	103.5	120.9	17.4	16.8
Алт	тн	7.5	22.8	10.8	14.1	3.3	30.6
Боловсруулаагүй нефть	сая.баррель	5.4	2.9	4.0	1.7	-2.3	-57.2
Катодын зэс	тн	8.6	6.3	8.5	7.1	-1.4	-16.2
Жоншны баяжмал	мян.тн	557.7	550.3	604.0	293.8	-310.3	-51.4
Адууны мах	мян.тн	16.9	13.0	7.0	2.7	-4.4	-61.9
Өлөн гэдэс	тн	332.8	431.8	480.4	504.3	24.0	5.0

Үхэр, адууны боловсруулсан шир	сая.дм2	62.6	23.4	7.5	7.6	0.1	1.8
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	589.8	296.7	441.4	88.8	-0.4	-79.9
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая.дм2	45.6	42.5	66.3	69.9	3.6	5.4
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая.дм2	109.1	78.7	69.5	66.1	-3.5	-5.0
Самнасан ноолуур	тн	440.3	228.9	306.9	736.2	429.4	139.9
Бохир ноолуур	тн	5,684.3	5,989.6	4,455.6	6,269.2	1,813.6	40.7
Хонины самнаагүй ноос	мян.тн	11.9	6.3	5.5	13.9	8.4	152.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 4. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/

Барааны төрөл	10 дугаар сар (өссөн дүнгээр)				Өмнөх оны мөн үеэс	
	2019	2020	2021	2022	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	1,541.0	1,345.7	2,624.3	2,342.8	-281.5	-10.7
Нүүрс	2,747.7	1,773.3	1,972.0	5,112.9	3,140.9	159.3
Төмрийн хүдэр	459.5	527.3	906.3	337.0	-569.2	-62.8
Цайрын баяжмал	155.6	141.5	160.8	245.9	85.1	52.9
Алт	344.3	1,322.2	628.0	817.2	189.2	30.1
Боловсруулаагүй нефть	302.8	105.1	249.7	170.1	-79.6	-31.9
Катодын зэс	48.8	34.5	76.1	60.5	-15.6	-20.5
Жоншны баяжмал	170.4	128.9	134.4	84.9	-49.5	-36.8
Адууны мах	32.2	24.9	14.6	8.5	-6.1	-41.7
Өлөн гэдэс	6.6	7.0	11.5	12.8	1.3	11.7
Үхэр, адууны боловсруулсан шир	5.7	2.3	0.8	0.6	-0.2	0.0
Үхэр, адууны боловсруулаагүй шир	1.8	0.4	0.7	0.6	-0.1	-20.0
Хонь, хурганы боловсруулсан арьс	1.1	0.9	1.3	1.3	-0.1	0.0
Ямаа, ишигний боловсруулсан арьс	3.6	2.9	2.3	1.4	-0.9	-38.2
Самнасан ноолуур	38.9	14.9	27.2	79.6	52.4	192.4
Бохир ноолуур	283.2	175.2	180.1	300.7	120.6	67.0
Хонины самнаагүй ноос	16.7	6.5	5.7	11.8	6.2	107.9
Нийт экспортод эзлэх хувь	94.4	93.8	93.0	95.8		

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 5. Эрдэс бүтээгдэхүүний экспортын дундаж үнэ

/ам.доллар/

Барааны нэр	Хэмжих нэгж	10 дугаар сар (өссөн дүнгээр)		Өөрчлөлт	
		2021	2022	Зөрүү	Хувь
Чулуун нүүрс	тн/ам.дол	146.5	221.3	74.7	51.0%
Зэсийн баяжмал	тн/ам.дол	2,264.5	1,951.5	-313.1	-13.8%
Төмрийн хүдэр, баяжмал	тн/ам.дол	138.2	86.9	-51.3	-37.1%
Цайрын хүдэр, баяжмал	тн/ам.дол	1,553.5	2,034.2	480.7	30.9%
Жоншны хүдэр, баяжмал	тн/ам.дол	222.4	288.9	66.4	29.9%
Алт	тн/ам.дол	58,122.4	57,910.2	-212.2	-0.4%

Эх сурвалж: Уул уурхайн яам

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оны мөн үеэс 2,384.4 сая ам.доллар буюу 34.0 хувиар өсөхөд голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

1.Нүүрс: 2022 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 23.1 сая тонн нүүрс экспортолж, 5,112.9 сая ам.долларын экспортын орлого олжээ. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 3,140.9 сая ам.доллар буюу 2.6 дахин, биет хэмжээгээр 9.6 сая.тн буюу 71.7 хувиар тус тус өссөн байна.

Чулуун нүүрсний 93.3 хувийг БНХАУ, 4.8 хувийг Бүгд Найрамдах Сингапур Улс, 1.9 хувийг бусад улс руу тус тус экспортолсон байна.

2.Зэсийн баяжмал: 2022 оны эхний 10 сарын байдлаар 2,342.8 сая ам.долларын 1,200.5 мян. тн зэсийн баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 281.5 сая ам.доллар буюу 10.7 хувиар буурч, биет хэмжээгээр 41.7 мян.тн буюу 3.6 хувиар өссөн байна. Зэсийн баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

3.Цайрын баяжмал: 2022 оны эхний 10 сарын байдлаар 245.9 сая ам.долларын 120.9 мян. тн цайрын баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 17.4 мян. тн буюу 16.8 хувиар, үнийн дүнгээр 85.1 сая ам.доллар буюу 52.9 хувиар тус тус өссөн байна. Цайрын баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

4.Алт: 2022 оны эхний 10 сарын байдлаар 817.2 сая ам.долларын 14,111.5 кг алт экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 189.2 сая ам.доллар буюу 30.1 хувиар, биет хэмжээгээр 3,306.9 кг буюу 30.6 хувиар тус тус өссөн байна. Алтны 93.8 хувийг Швейцар, 6.2 хувийг БНСУ руу тус тус экспортолсон байна.

Гурав. Гол нэр төрлийн импортын бүтээгдэхүүн

Нийт импортын 22.1 хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, 77.9 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт 5,564.7 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 911.4 сая ам.доллар буюу 19.6 хувиар өссөн байна. Эрдсийн бүтээгдэхүүний импорт 1,580.8 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 589.0 сая ам.доллароор буюу 59.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 6. Эрдсийн болон эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	10 дугаар сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2019	2020	2021	2022	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	1,120.9	807.6	991.8	1,580.8	589.0	59.4	22.1
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	3,943.6	3,629.4	4,653.3	5,564.7	911.4	19.6	77.9
Нийт импорт	5,064.6	4,437.0	5,645.2	7,145.6	1,500.4	26.6	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын барааны бүтцийн хувьд эрдэс бүтээгдэхүүн 22.1 хувь, авто болон агаарын, усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 18.3 хувь, машин механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг 14.8 хувь, мал амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний

зүйл 13.3 хувь, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн 9.7 хувь, химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн 7.3 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 7. Импортын гүйцэтгэл, барааны бүлгээр

/сая ам.доллар/

№	Барааны нэр	Импорт		Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
		2022.10	2022.10	Дүн	Хувь	
1	Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	101.0	120.5	19.5	19.3	1.7
2	Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	158.9	120.2	-38.7	-24.3	1.7
3	Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	36.6	46.6	10.0	27.4	0.7
4	Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	488.4	658.5	170.1	34.8	9.2
5	Эрдэс бүтээгдэхүүн	991.8	1,580.8	589.0	59.4	22.1
6	Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	472.8	518.9	46.1	9.8	7.3
7	Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс, хаймар болон түүгээр хийсэн зүйлс	211.9	289.9	78.0	36.8	4.1
8	Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	5.4	7.8	2.4	45.2	0.1
9	Мод, модон эдлэл	52.8	69.7	16.9	32.0	1.0
10	Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс	52.6	83.1	30.5	57.9	1.2
11	Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл	85.5	110.0	24.5	28.6	1.5
12	Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	18.7	28.6	9.9	52.9	0.4
13	Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	142.8	209.7	66.8	46.8	2.9
14	Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	5.0	6.4	1.4	28.5	0.1
15	Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	512.8	696.0	183.2	35.7	9.7
16	Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	1,050.9	1,056.5	5.6	0.5	14.8
17	Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги	1,065.5	1,305.5	240.0	22.5	18.3
18	Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг, тэдгээрийн эд анги	107.8	112.2	4.4	0.0	0.0
19	Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	81.1	122.8	41.7	0.1	0.0
20	Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	0.1	0.2	0.0	0.0	0.0
21	ДҮН	5,645.2	7,145.6	1,501.4	26.6	100.0
	ДҮН	4,473.8	5,599.4	1,125.5	25.2	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Эрдэс бүтээгдэхүүний импортын үнийн дүнгийн 87.5 хувийг газрын тосны бүтээгдэхүүн эзэлж байна.

2022 оны эхний 10 сарын байдлаар 1,382.9 сая ам.долларын 1,476.8 мян.тн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 94.5 мян.тн буюу 6.8 хувиар, үнийн дүнгээр 555.9 сая ам.доллар буюу 67.2 хувиар тус тус өссөн байна.

Газрын тосны бүтээгдэхүүний импортын нийт үнийн дүнгийн 87.9 хувийг автобензин, дизель түлшний импорт, үүний 33.2 хувийг автобензин, 54.7 хувийг дизель түлшний импорт тус тус эзэлж байгааг салбарын яамны статистик мэдээнд дурджээ.

Дөрөв. Улсын төсвийн гаалийн орлого бүрдэлт

Гаалийн байгууллага нь 2022 оны тодотгосон төсвөөр эхний 10 сард улсын төсөвт 3,495.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх

төлөвлөгөөтэйгээс 3,820.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь 9.3 хувиар давж биелсэн байна.

Хүснэгт 8. Татварын орлогын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2021.10		2022.10		Өмнөх оны мөн үетэй харьцуулахад		Төлөвлөгөөтэй харьцуулахад	
	Гүйц.	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь	Зөрүү	Хувь	
НИЙТ ОРЛОГО	2,859.5	3,495.8	3,820.9	961.4	133.6	325.1	109.3	
Өөрийн орлого	4.6	14.8	13.4	8.7	291.3	-1.4	90.5	
Хураамж	34.3	45.9	45.7	11.4	133.2	-0.2	99.6	
Татварын дүн	2,820.6	3,435.0	3,761.9	941.3	133.4	326.9	109.5	
Гаалийн албан татвар	771.7	908.0	1056.8	285.1	136.9	148.8	116.4	
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,554.5	1,894.8	2,207.0	652.5	142.0	312.2	116.5	
Архи, дарсны онцгой албан татвар	13.7	18.2	21.9	8.2	159.9	3.7	120.3	
Тамхины онцгой албан татвар	108.7	133.3	120.9	12.2	111.2	-12.4	90.7	
Шар айрагны онцгой албан татвар	4.2	2.9	7.7	3.5	183.3	4.8	265.5	
Суудлын автомашины онцгой албан татвар	162.4	222.9	245.2	82.8	151.0	22.3	110.0	
Автобензин, дизель түлшний онцгой албан татвар	193.3	241.6	86.9	-106.3	45.0	-154.7	36.0	
Автобензин, дизель түлшний албан татвар	12.0	13.2	15.5	3.5	129.2	2.3	117.4	
Экспортын татвар	0.037	0.031	0.005	-0.032	0.0	0.0	0.0	

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал нийт орлого өнгөрсөн оны мөн үеэс 961.4 тэрбум төгрөг буюу 33.6 хувиар өссөн байна. Үүнээс:

- Гаалийн албан татвар 285.1 тэрбум төгрөг,
- Нэмэгдсэн өртөгийн албан татвар 652.4 тэрбум,
- Архи, дарсны онцгой албан татвар 8.2 тэрбум төгрөг,
- Тамхины онцгой албан татвар 12.2 тэрбум төгрөг,
- Суудлын автомашины онцгой албан татвар 82.8 тэрбум төгрөг,
- Өөрийн орлого 8.7 тэрбум төгрөг,
- Автобензин, дизелийн түлшний албан татвар 3.5 тэрбум төгрөг,
- Хураамжийн орлого 11.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн.

Харин автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар 106.3 тэрбум төгрөг, экспортын орлого 32 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Зарим төрлийн импортын бараанд ногдуулсан онцгой албан татварын орлого бүрдэлт, импортын тоо хэмжээний талаар:

Онцгой албан татвартай суудлын автомашин: Тус барааны онцгой албан татвараар 2022 оны эхний 10 сард 222.9 тэрбум төгрөг төсөвт төвлөрүүлэхээс 245.2 тэрбум төгрөг төвлөрүүлж 110.0 хувийн гүйцэтгэлтэй, өнгөрсөн оны мөн үетэй орлогыг харьцуулахад 82.8 тэрбум төгрөгөөр өсөлттэй гарчээ. Тайлант хугацаанд онцгой албан татвартай суудлын автомашин 56,669 ширхэг импортолсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 11,494 ширхэг буюу 25.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс хос тэжээлт болон шингэрүүлсэн хийгээр ажилладаг суудлын автомашин 7,923 ширхэгээр, бусад суудлын автомашин 3,571 ширхэгээр тус тус өссөн.

Хүснэгт 9. Онцгой албан татвартай суудлын автомашины импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар

Төрөл	Импортын тоо хэмжээ /ширхэг/				Ногдуулсан татвар /тэрбум төгрөг/			
	2021.10	2022.10	Зөрүү	Хувь	2021.10	2022.10	Зөрүү	Хувь
Хос тэжээлт	33,966	41,889	7,923	123.3%	104.3	156.6	52.3	150%
Бусад	11,209	14,780	3,571	131.9%	58.7	88.7	30.0	151%
Нийт	45,175	56,669	11,494	125.4%	163.0	245.4	82.4	151%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Автобензин, дизелийн түлш: Монгол улс шатахууны хэрэгцээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд 2021 оны эхний 10 сард 1,220.62 мянган тн, 2022 оны эхний 10 сард 1,318.45 мянган тн автобензин, дизелийн түлшний бүтээгдхүүн импортолсон байна.

Хүснэгт 10. Автобензин, дизелийн түлшний импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар

Төрөл		Импортын тоо хэмжээ /мян.тонн/				Ногдуулсан татвар /тэрбум төгрөг/			
		2021.10	2022.10	Зөрүү	Хувь	2021.10	2022.10	Зөрүү	Хувь
Нийт		1,220.6	1,318.5	97.8	108.0	186.9	53.6	-133.3	28.7
Автобензин	A-80	43.1	29.0	-14.1	67.3	-	-	-	-
	A-92	353.1	0.2	-353.0	0.1	-	-	-	-
	A-95 болон түүнээс дээш	21.0	501.0	480.1	2389.9	4.4	-	-4.4	-
Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин		-	-	-	100	-	-	-	100
Дизель түлш		803.4	788.2	-15.2	98.1	182.5	53.6	-128.9	29.4

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Тав. Татварын чөлөөлөлт

2022 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр нийт татвараас чөлөөлөгдсөн импорт үнийн дүнгээр 1,374.0 тэрбум төгрөг буюу нийт импортын 6.3 хувийг эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татвартай импорт 6,193.8 тэрбум төгрөгөөр буюу 43.1 хувиар өссөн бол, татвараас

чөлөөлөгдсөн импорт 318.5 тэрбум төгрөгөөр буюу 18.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Татвараас чөлөөлөгдсөн импортын нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна

Хүснэгт 11. Импортын бүтэц

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2021.10	2022.10	Өөрчлөлт (+,-)	Хувиар
Татвартай импорт	14,377.34	20,571.18	6,193.8	143.1%
<i>Эзлэх хувь</i>	<i>89.4%</i>	<i>93.7%</i>	<i>4.3%</i>	
Татвараас чөлөөлөгдсөн импорт	1,698.51	1,379.96	-318.5	81.2%
<i>Эзлэх хувь</i>	<i>10.6%</i>	<i>6.3%</i>	<i>-4.3%</i>	
Нийт импорт	16,075.8	21,951.1	5,875.3	136.5%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2022 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 1,379.96 тэрбум төгрөгийн импортын бараанд ногдох 198.2 тэрбум төгрөгийн татвар хуулийн дагуу чөлөөлөгдсөн байна. Чөлөөлөгдсөн татварын дүнг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 84.2 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

- 1) Засгийн газрын болон Олон улсын байгууллагатай байгуулсан тусламжийн хүрээнд 193.3 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий 29.4 тэрбум тэрбум төгрөг,
- 2) БНМАУ-ЗСБНХУ-ын хооронд байгуулсан 1949 оны хэлэлцээр, мөн УИХ-ын 2016-09-07-ны өдрийн “Онцгой албан татвараас чөлөөлөгдөх тухай хууль”-аар Улаанбаатар төмөр зам” нийгэмлэг нь 235.78 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд 42.98 тэрбум төгрөг,
- 3) Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг болох 27.0 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан 3.3тэрбум төгрөг,
- 4) Засгийн газрын болон Олон улсын байгууллагатай байгуулсан зээлийн хүрээнд 69.7 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд 10.8 тэрбум төгрөг,
- 5) ХАА-ын зориулалттай тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис бүхий нийт 125.3 тэрбум төгрөгийг статистик дүн бүхий бараанд ногдуулсан 13.2 тэрбум төгрөг,
- 6) Бусад татварын хуулийн зүйл заалтуудаар 114.9 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд 16.1 тэрбум төгрөгийн татварыг тус тус чөлөөлсөн байна.

Хүснэгт 12. Татварын чөлөөлөлт

/тэрбум төгрөг/

Д/д	Үзүүлэлт	2021.10		2022.10		Өөрчлөлт 2022/2021	
		үнийн дүн	чөлөөлсөн татвар	үнийн дүн	чөлөөлсөн татвар	үнийн дүн	чөлөөлсөн татвар
1	ХАА-н зориулалттай тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис	74.33	7.8	125.3	13.2	51.0	5.4
2	Засгийн газрын болон Олон улсын байгууллагын тусламж	103.48	15.8	193.3	29.4	89.9	13.6
3	Гадаадын хөрөнгө оруулалт: УБТЗ болон газрын тосны компаниудын тоног төхөөрөмж	229.15	59.8	239.5	43.6	10.3	-16.3
4	Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг	28.23	3.6	27.0	3.3	-1.3	-0.4
5	Иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг онгоц, түүний сэлбэг	91.99	14.3	293.40	51.07	201.4	36.8
6	Засгийн газрын болон олон улсын байгууллагын зээл	249.11	40.5	69.7	10.8	-179.4	-29.7
7	Хийн түлш тэдгээрийн тоног төхөөрөмж	57.95	9.0	64.2	10.0	6.3	1.0
8	Улаанбуудайн үр, хүнсний улаанбуудай, бүх төрлийн хүнсний будаа, элсэн чихэр, ургамлын тос	320.68	48.9	170.2	8.5	-150.4	-40.4
9	Бусад	543.59	82.7	114.9	16.1	-428.7	-66.6
9	Дүн	1,698.5	282.4	1,379.4	198.2	-319.1	-84.2

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**